



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар аймгийн Баяндэлгэр сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** СБА-2023/72/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Баруун-Урт сум 2023 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: М.Баяндэлгэртуяа Утас: 70518396 Аудитын менежер: Г.Даваа Утас: 70512123 Аудитор: Б.Мөнхбамбар Утас: 70512127</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

<b>1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ</b> .....	3
<b>2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ</b> .....	5
<b>3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА</b> .....	11
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин .....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	12
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	13
<b>4. АУДИТЫН ТАЙЛАН</b> .....	14
<b>4.1 Ерөнхий зүйл</b> .....	14
<b>4.2 Материаллаг байдал</b> .....	14
<b>4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт</b> .....	14
<b>4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал</b>	15
<b>4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт</b> .....	15
<b>4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт</b> .....	15
<b>4.5.1 Завсрын аудитын талаар</b> .....	15
<b>5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ</b> .....	15
<b>5.1 Төлбөрийн акт</b> .....	15
<b>5.2 Албан шаардлага</b> .....	16
<b>6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ</b> .....	16

**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



## СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг  
Утас: 70518396, Факс: 70518396  
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

СҮХБААТАР АЙМГИЙН БАЯНДЭЛГЭР  
СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН  
ДАРГА Ц.ЖИГМЭДСҮРЭН ТАНАА

2023.02.24 № 76

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сүхбаатар аймгийн Баяндэлгэр сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сүхбаатар аймгийн Баяндэлгэр сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын үйл ажиллагааны тасралтгүй байх зарчим, холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээний анхаарал татсан асуудал болон санхүүгийн тайлангийн хойших үйл явдал, бусад асуудлын талаар тодорхойгүй байдал үүсээгүй болно.

### Аудитын гол асуудал

Сүхбаатар аймгийн Баяндэлгэр сумын Эрүүл мэндийн төв ЭМДС-аас өмнөх оны авлагын үлдэгдэл 170.2 сая төгрөгийг Төсвийн тухай хуулийн дагуу төсвийн ерөнхийлөн захирагчид хүсэлт хүргэж, эх үүсвэр нь дутагдаж байгаа зардлуудад төлөвлөн, зарцуулсан байна.

### Бусад асуудлын хэсэг

Сүхбаатар аймгийн Баяндэлгэр сумын Эрүүл мэндийн төвийн 2022 гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нийт 7 зорилт, 64 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж гүйцэтгэлээр 90 хувийн биелэлттэй хэрэгжүүлсэн байна.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

D:/Bichig hereg/2023/A4 toot

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.НАРАНТУЯА

**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ****2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>216,453,129.42</u></b>	<b><u>139,601,262.67</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	992,510.74	46,436,655.27
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	992,510.74	46,436,655.27
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	992,510.74	46,436,655.27
31211	Төрийн сангийн харилцах	16,510.74	46,436,655.27
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	976,000.00	-
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	170,387,532.56	-
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	191,732.56	-
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	170,195,800.00	-
3351	Байгууллагаас авах авлага	170,195,800.00	-
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	45,073,086.12	93,164,607.40
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	17,875,951.12	38,463,727.40
35130	Эм боох материал	17,875,951.12	38,463,727.40
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	25,292,135.00	53,760,880.00
35410	Бичиг хэргийн материал	181,000.00	324,400.00
35420	Аж ахуйн материал	5,979,425.00	14,639,390.00
35460	Хүнсний материал	1,256,800.00	2,301,550.00
35470	Бусад хангамжийн материал	17,874,910.00	36,495,540.00
35600	Мал амьтад	1,905,000.00	940,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>563,366,995.37</u></b>	<b><u>1,116,540,708.66</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	563,366,995.37	1,116,540,708.66
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	551,985,842.38	1,103,428,222.31
39201	Барилга, байгууламж, орон сууц	259,449,336.19	486,089,336.19
39202	Хуримтлагдсан элэгдэл	(14,021,096.44)	(19,536,185.29)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	58,800,000.00	182,800,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(15,440,000.16)	(23,700,000.24)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	383,198,095.70	559,664,337.78
39206	Хуримтлагдсан элэгдэл	(142,026,418.22)	(162,174,365.81)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	41,234,261.90	53,397,439.40
39208	Хуримтлагдсан элэгдэл	(32,772,336.63)	(11,700,089.86)
39214	Бусад үндсэн хөрөнгө	22,130,000.00	49,470,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(8,565,999.96)	(10,882,249.86)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	11,381,152.99	13,112,486.35
39301	Програм хангамж	1,320,000.00	2,765,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,132,847.01)	(846,513.65)
39303	Бусад биет бус хөрөнгө	11,194,000.00	11,194,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>779,820,124.79</u></b>	<b><u>1,256,141,971.33</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>831,000.00</u></b>	<b>=</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	831,000.00	-

<b>413</b>	<b>Өглөг</b>	831,000.00	-
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	831,000.00	-
41361	Байгууллагад төлөх өглөг	831,000.00	-
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>778,989,124.79</u></b>	<b><u>1,256,141,971.33</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	778,989,124.79	1,256,141,971.33
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	459,945,565.64	459,945,565.64
51101	Өмч: - төрийн	459,945,565.64	459,945,565.64
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	180,028,781.34	657,181,627.88
51210	Өмнөх үеийн үр дүн	180,028,781.34	180,028,781.34
51220	Тайлант үеийн үр дүн	-	477,152,846.54
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	139,014,777.81	139,014,777.81
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>779,820,124.79</u></b>	<b><u>1,256,141,971.33</u></b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,241,826,241.20</b>	<b>1,416,675,523.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>468,488,745.20</b>	<b>564,181,093.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	468,488,745.20	564,181,093.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	468,488,745.20	564,181,093.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	306,505,400.00	6,801,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	161,983,345.20	557,380,093.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>773,337,496.00</b>	<b>852,494,430.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	485,005,600.00	-
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	485,005,600.00	-
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	51,490,496.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	51,490,496.00	-
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	31,139,300.00	40,446,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	31,139,300.00	40,446,700.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	205,702,100.00	812,047,730.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	205,702,100.00	812,047,730.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>897,292,754.35</b>	<b>934,042,753.54</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>897,292,754.35</b>	<b>934,042,753.54</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	854,434,397.60	927,222,674.35
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	432,754,187.70	496,861,549.47
210101	Үндсэн цалин	207,134,815.42	264,366,122.56
210102	Нэмэгдэл	183,121,224.92	159,382,611.07

210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,821,000.00	5,992,000.00
210104	Урамшуулал	36,677,147.36	67,120,815.84
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	60,355,149.53	64,862,822.56
210201	Тэтгэврийн даатгал	45,069,249.53	46,631,404.56
210202	Тэтгэмжийн даатгал	3,939,200.00	4,730,583.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,151,500.00	3,792,556.00
210204	Ажилгүйдлийн даатгал	787,900.00	1,098,670.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,407,300.00	8,609,609.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	24,628,943.25	26,923,120.81
210301	Гэрэл, цахилгаан	4,179,212.13	4,347,920.01
210302	Түлш, халаалт	20,449,731.12	22,310,800.80
210303	Цэвэр, бохир ус	-	264,400.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	73,726,767.00	62,356,174.00
210401	Бичиг хэрэг	5,094,000.00	4,067,780.00
210402	Тээвэр, шатахуун	24,185,400.00	26,746,799.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,060,000.00	3,194,300.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	9,830,350.00	8,772,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	31,557,017.00	19,575,195.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	194,845,803.01	120,603,834.72
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	177,879,210.51	101,805,884.72
210502	Хоол, хүнс	13,238,592.50	15,299,950.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,728,000.00	3,498,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	15,804,178.00	42,052,149.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	10,935,458.00	12,260,130.00
210602	Тавилга	-	1,200,000.00
210604	Урсгал засвар	4,868,720.00	28,592,019.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	682,000.00	1,377,000.00
210701	Гадаад албан томилолт	682,000.00	-
210702	Дотоод албан томилолт	-	1,377,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	13,813,631.00	24,828,123.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	13,813,631.00	24,828,123.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	37,823,738.11	87,357,900.79
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,327,920.00	29,623,460.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	33,495,818.11	57,734,440.79
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	42,858,356.75	6,820,079.19
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	42,700,000.00	3,300,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	42,700,000.00	3,300,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	158,356.75	3,520,079.19
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	158,356.75	3,520,079.19
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>344,533,486.85</b>	<b>482,632,769.46</b>

225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	5,479,922.92
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	697,499.92
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал		4,782,423.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(5,479,922.92)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<b><u>344,533,486.85</u></b>	<b><u>477,152,846.54</u></b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<b><u>913,127,096.00</u></b>	<b><u>1,029,491,230.00</u></b>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	<b>791,511,000.00</b>	<b>10,281,000.00</b>
120	Нийтлэг татварын бус орлого	306,505,400.00	10,281,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	306,505,400.00	10,281,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	306,505,400.00	10,281,000.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	485,005,600.00	-
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	485,005,600.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛГИЙН ОРЛОГО	<b>121,616,096.00</b>	<b>1,019,210,230.00</b>
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	51,490,496.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	51,490,496.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	31,139,300.00	40,446,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	31,139,300.00	40,446,700.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	38,986,300.00	978,763,530.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	38,986,300.00	978,763,530.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<b><u>865,548,485.26</u></b>	<b><u>878,834,205.47</u></b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	<b>865,548,485.26</b>	<b>878,834,205.47</b>
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	<b>822,690,128.51</b>	<b>872,014,126.28</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	433,008,606.26	496,861,549.47
210101	Үндсэн цалин	207,389,233.98	264,366,122.56
210102	Нэмэгдэл	185,643,981.92	159,382,611.07
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,821,000.00	5,992,000.00
210104	Урамшуулал	34,154,390.36	67,120,815.84
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	59,738,519.00	64,671,090.00
210201	Тэтгэврийн даатгал	44,452,619.00	46,439,672.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,939,200.00	4,730,583.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,151,500.00	3,792,556.00
210204	Ажилгүйдлийн даатгал	787,900.00	1,098,670.00

210205	Эрүүл мэндийн даатгал	7,407,300.00	8,609,609.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	25,161,343.25	27,550,120.81
210301	Гэрэл, цахилгаан	5,429,612.13	4,682,420.01
210302	Түлш, халаалт	19,731,731.12	22,603,300.80
210303	Цэвэр, бохир ус	-	264,400.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	67,320,020.00	52,405,679.00
210401	Бичиг хэрэг	4,786,100.00	3,861,780.00
210402	Тээвэр, шатахуун	24,114,000.00	26,746,799.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,060,000.00	3,129,300.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	6,500,000.00	4,381,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	28,859,920.00	14,286,300.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	192,644,077.00	128,309,665.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	174,282,977.00	107,911,965.00
210502	Хоол, хүнс	13,061,100.00	16,624,700.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,300,000.00	3,773,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	22,893,078.00	46,956,549.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	16,233,078.00	13,365,330.00
210602	Тавилга	1,660,000.00	2,655,000.00
210604	Урсгал засвар	5,000,000.00	30,936,219.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	682,000.00	1,377,000.00
210702	Дотоод албан томилолт	682,000.00	1,377,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	14,999,945.00	24,828,123.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	14,999,945.00	24,828,123.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	6,242,540.00	29,054,350.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,242,540.00	29,054,350.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>42,858,356.75</b>	<b>6,820,079.19</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	42,700,000.00	3,300,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	42,700,000.00	3,300,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	158,356.75	3,520,079.19
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	158,356.75	3,520,079.19
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>47,578,610.74</u></b>	<b><u>150,657,024.53</u></b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>46,586,100.00</b>	<b>105,212,880.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>46,586,100.00</b>	<b>105,212,880.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	46,586,100.00	105,212,880.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	46,586,100.00	105,212,880.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>(46,586,100.00)</u></b>	<b><u>(105,212,880.00)</u></b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	992,510.74	45,444,144.53

9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		992,510.74
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	992,510.74	46,436,655.27

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нооц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	459,945,565.64	139,014,777.81	(164,504,705.51)		434,455,637.94
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	459,945,565.64	139,014,777.81	(164,504,705.51)	-	434,455,637.94
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	344,533,486.85		344,533,486.85
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	459,945,565.64	139,014,777.81	180,028,781.34	-	778,989,124.79
D01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	459,945,565.64	139,014,777.81	180,028,781.34	-	778,989,124.79
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	459,945,565.64	139,014,777.81	180,028,781.34	-	778,989,124.79
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	477,152,846.54		477,152,846.54
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	459,945,565.64	139,014,777.81	657,181,627.88	-	1,256,141,971.33

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	1110696401.00	980527006.28
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	1110696401.00	980527006.28
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1107396401.00	977227006.28
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	526088000.00	496861549.47
210101	Үндсэн цалин	208609400.00	264366122.56
210102	Нэмэгдэл	255071800.00	159382611.07
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7098000.00	5992000.00
210104	Урамшуулал	55308800.00	67120815.84
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	74766500.00	64671090.00
210201	Тэтгэврийн даатгал	53869600.00	46439672.00
210202	Тэтгэмжийн даатгал	5213800.00	4730583.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4046800.00	3792556.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1180800.00	1098670.00
210205	Эрүүл мэндийн даатгал	10455500.00	8609609.00
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	30951700.00	27550120.81
210301	Гэрэл, цахилгаан	5528000.00	4682420.01
210302	Түлш, халаалт	23823700.00	22603300.80
210303	Цэвэр, бохир ус	1600000.00	264400.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	75739800.00	57405679.00
210401	Бичиг хэрэг	6703900.00	3861780.00
210402	Тээвэр, шатахуун	30847700.00	26746799.00

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,133,600.00	3,129,300.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	14,642,100.00	9,381,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	19,412,500.00	14,286,300.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>151,293,401.00</b>	<b>128,309,665.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	121,815,000.00	107,911,965.00
210502	Хоол, хүнс	22,728,501.00	16,624,700.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,749,900.00	3,773,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>159,095,400.00</b>	<b>134,670,439.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	93,795,400.00	81,243,230.00
210602	Тавилга	21,300,000.00	19,970,990.00
210604	Урсгал засвар	44,000,000.00	33,456,219.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,879,500.00</b>	<b>1,377,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	1,879,500.00	1,377,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>43,440,700.00</b>	<b>37,123,123.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	38,945,700.00	32,628,123.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,495,000.00	4,495,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>44,141,400.00</b>	<b>29,258,340.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	44,141,400.00	29,258,340.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>3,300,000.00</b>	<b>3,300,000.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>3,300,000.00</b>	<b>3,300,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,300,000.00	3,300,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,110,696,400.00</b>	<b>1,029,491,230.00</b>
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>40,446,700.00</b>	<b>40,446,700.00</b>
132001	Орон нутгийн төсвөөс	40,446,700.00	40,446,700.00
<b>1340</b>	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,070,249,700.00</b>	<b>978,763,530.00</b>
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,070,249,700.00	978,763,530.00
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	-	<b>10,281,000.00</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	10,281,000.00
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>992,510.74</b>
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		<b>46,436,655.27</b>

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сүхбаатар аймгийн Баяндэлгэр сумын Эрүүл мэндийн төв “Үйлчлэх хүрээний хүн амд, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг дэвшилтэд технологид тулгуурлан тэгш хүртээмжтэй, хэнийг ч орхигдуулалгүй үзүүлэхэд оршино” эрхэм зорилгын хүрээнд хүн амд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх зорилго, үндсэн чиг үүргийг хэрэгжүүлж байна.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 01 дүгээр тогтоол “Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах журам”
- Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 06 дүгээр тогтоол “Багц, төлбөрийн хэмжээ, журам батлах тухай”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзсэн.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар аймгийн Баяндэлгэр сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сүхбаатар аймгийн Баяндэлгэр сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 476,322.68 мянган төгрөгөөр буюу 62 хувиар өссөн байна.

#### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
<b>Б</b>	1	2	3=2-1
<b>Мөнгөн хөрөнгө</b>	992.5	46,436.6	45,444.1
<b>Авлага</b>	170,387.5	0.0	-170,387.5
<b>Бараа материал</b>	45,073.1	93,164.6	48,091.5
<b>Үндсэн хөрөнгө</b>	563,367.0	1,116,540.7	553,173.7
<b>Нийт хөрөнгө</b>	<b>779,820.1</b>	<b>1,256,141.9</b>	<b>476,321.8</b>
<b>Өр төлбөр</b>	830.0	0.0	-830.0
<b>Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/</b>	778,989.1	1,256,141.9	477,152.8

Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	779,819.1	1,256,141.9	476,322.8
---------------------------------------	-----------	-------------	-----------

- Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 45,444.1 мянган төгрөгөөр өссөн нь ЭМД-ын гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн үлдэгдэл байна.
- Авлагын данс 170,387.5 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны эрүүл мэндийн даатгалын сангаас авах авлага барагдсан нь нөлөөлсөн байна.
- Үндсэн хөрөнгө данс 1,116,540.7 мянган төгрөг болж 553,1736.7 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь төсвийн хөрөнгөөр 105,212.8 мянга, үнэ төлбөргүй 495,892.8 мянга, шилжүүлж авсан 10,500.0 мянга нийт 611,605.6 мянган төгрөгөөр нэмэгдэж, 43,551.2 мянган төгрөг хөрөнгийг акталж, хөрөнгийн элэгдлээр буурсан нөлөөлсөн байна.
- Засгийн газрын хувь оролцоо данс 477,152.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант үеийн үр дүн нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Эрүүл мэндийн салбарын төсвийн төсөл боловсруулах процесс өөрчлөгдөж ЭМДС-ийн санхүүжилтийг Эрүүл мэндийн үндэсний зөвлөлийн 01, 05 дугаар тогтоолын дагуу хүн амын тоо, насны ангилал, хүйс, хот хоорондын зайнаас хамааруулж нэг иргэнд ноогдох норматив зардал, үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээний санхүүжилтийг тухайн жилийн тоон үзүүлэлтэд тулгуулан төсвийн төслийг боловсруулдаг.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг ЭМДС-аас санхүүжилт 1,070,249.7 мянга, орон нутгийн санхүүжилт 40,446.7 мянга нийт 1,110,696.4 мянган төгрөгөөр төсөв батлагдсанаас 980,527.0 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулжээ.

Гүйцэтгэлээр харилцах дансны эхний үлдэгдэл 992.5 мянга, ЭМД-ийн сангаас 978,763.5 мянга, орон нутгийн санхүүжилт 40,446.7 мянга, үндсэн үйл ажиллагааны орлогоос 10,281.0 мянга, нийт 1,030,483.7 мянган төгрөгийн санхүүжилт олгож, орон нутгийн санхүүжилтээс 3,520.1 мянган төгрөгийг төвлөрүүлсэн бөгөөд мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 46,436.6 мянган төгрөг байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 980,527.0 мянган төгрөг буюу 88 хувьтай зарцуулсан байна.

#### Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
1	80111-Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	35,951.7	32,431.6	3,520.1	90%
2	83201- Ангилалдаагүй бусад зориулалт	4,495.0	4,495.0	0.0	100%
3	80302-Нэг иргэнд ногдох нормативаар тооцсон	390,995.4	353,883.3	37,112.1	91%
4	81603-Үндсэн мэргэжлийн тусламж	400,662.9	356,885.6	43,777.3	89%
5	83603-Нэмэлт-дээд шатны төсвөөс хуваарилсан	278,591.4	232,831.5	45,759.9	84%
НИЙТ		1,110,696.4	980,527.0	130,169.4	

Нэг иргэнд ноогдох нормативаар тооцсон, үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээний санхүүжилтээс 80,212.7 мянган төгрөг хэмнэгдсэн байна. Энэ нь боловсон хүчин дутмаг, зарим эрүүл мэндийн тусламж үйлчилгээ Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоолын шалгуурт нийцээгүйтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн**

Тайлант хугацаанд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхээр төлөвлөөгүй байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сүхбаатар аймгийн Баяндэлгэр сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Мөнхбамбар, гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Даваа, дарга, тэргүүлэх аудитор М.Нарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар аймгийн Баяндэлгэр сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 05 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны нийт зардлын 923,407.1 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 18,468.1 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоов.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1<sup>1</sup>, 15.2.3<sup>2</sup>-т зардлын хэмнэсэн эсэхийг өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулж үзэхэд байр ашиглалттай холбоотой тогтмол

---

<sup>1</sup> байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээг хэмнэх;

<sup>2</sup> сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх;

зардлууд 2,294.2 мянган төгрөгөөр өсөж, хангамж, бараа материалын зардлууд 11,445.6 мянган төгрөгөөр тус тус буурсан байна.

#### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим системд тайлант онд гарсан өмч, хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой гаргасан тушаал шийдвэр, орлого зарлагын мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн байршуулсан байна.

##### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

###### 4.5.1 Завсрын аудитын талаар

Сүхбаатар аймгийн Баяндэлгэр сумын эрүүл мэндийн төвд завсрын аудит хийгээгүй.

###### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

*Өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн байна.*

Хүснэгт 3 Албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		/мянган төгрөгөөр/ Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	-	-	-	-	-
Зөвлөмж	2	-	2	-	100
Нийт дүн	2	-	2	-	100

#### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 13,906.8 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 2,277.4 мянган төгрөгийг зөрчил<sup>3</sup> илэрч 2 төлбөрийн акт тогтоож, 11,629.4 мянган төгрөгийн зөрчлийн арилгах 1 албан шаардлага хүргүүлэв.

##### 5.1 Төлбөрийн акт

Төрийн албан хаасан хугацааны нэмэгдлийн 1,569.5 мянган төгрөгөөр илүү бодож олгосон нь төсвийг үр ашиггүй зарцуулсан. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6

<sup>3</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

